



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайла

Аудитын код: ГАА-2024/07/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: 03	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидсүх
Алтай хот	Утас: 99998431 Цахим хаяг: gunjid@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: erdene@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhand@audit.gov.mn



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402. Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.01.26 № 02

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөтөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой 3 улсын байцаанын орон тоо нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 468,063.0 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 4 зорилт, 77 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 72 арга хэмжээг бүрэн, 5 арга хэмжээг 70.0 хувь буюу нийт дүнгээр 80.6 хувиар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

07000000

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гаж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a circular official stamp of the Mongolian State Audit Agency. The stamp contains the text 'МОНГОЛ УЛСЫН АУДИТ АГЫН ТӨСВИЙН АУДИТ' (Mongolian State Audit Agency's State Audit) and 'ТӨСВИЙН АУДИТ' (State Audit). A handwritten signature in black ink is written across the stamp. To the right of the stamp, there is a horizontal line that extends to the right, ending at the name 'Г. ГҮНЖИДМАА'.

Г. ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	32,145.9	25,772.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	912,110.4	736,090.6
Нийт хөрөнгийн дүн	944,256.4	761,862.7
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	944,256.4	761,862.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	944,256.4	761,862.7
Үйл ажиллагааны орлогын дүн	980,656.4	1,315,737.2
Үйл ажиллагааны зардлын дүн	908,850.6	1,381,629.3
Үйл ажиллагааны үр дүн	71,805.8	(65,892.2)
Үйл ажиллагааны бус үр дүн	3,629.5	0.0
Үйл ажиллагааны нийт үр дүн	68,176.3	(65,892.2)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,080.04	827,754.8
Тайлант оны үр дүн	(47,563.66)	(65,892.2)
Эцсийн үлдэгдэл	827,754.8	761,862.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	842,077.90	1,310,141.0
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	842,077.90	1,308,711.0
Үйл ажиллагааны ЦМГ	0.0	1,430.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	0.0	(1,430.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	793,765.46	1,227,776.4
Урсгал зардал	793,765.46	1,226,346.4
Хөрөнгийн зардал		1,430.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	793,765.46	1,227,776.38
Улсын төсвөөс санхүүжих	740,681.46	1,155,463.38
Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,084.00	67,400.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 14,295.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 14,295.7 мянган төгрөгийг тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т заалт, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98 дүгээр стандартын заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан (буруу ойлгосон), хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 7,238.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 1,626.1 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 542.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 5,070.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Төлбөрийн акт

1. Санхүүгийн тайлан гаргаагүй нягтлан бодогчид 1,114.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн А/206 дугаар тушаал "Урамшуулал олгох тухай"-тай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшуулал 1,114.0 мянган төгрөгийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Шатахууны зардлаас 512.1 мянган төгрөгийг дуудсан бичиг, томилолтын хуудас, илтгэх хуудасгүйгээр шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дуудсан бичиг, томилолтын хуудасгүй зарцуулсан 512.1 мянган төгрөгийн шатахууныг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Эд хариуцагч нь 542.0 мянган төгрөгийн /бичгийн цаас, будаг, гэрэл/ материалыг өөртөө шаардах хуудас бичиж зарлагадсан нь анхан шатны баримтын шаардлага хангахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ын тухай хууль, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмээ мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Хүнсний зардалд 33,479.5 мянган төгрөг зарцуулсан боловч худалдан авах ажиллагаа тендер зарлаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ур чадварын нэмэгдлийг олгохдоо шалгуурын дагуу дүгнээгүй, сар бүр хавтгайруулан жилийн турш 21,938.3 мянган төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаал "төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 1996 оны 04 сарын 20-ны өдрийн 63, 04 дүгээр тушаал "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ын 5-д "ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна", 7-д "7.Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно."-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварыг нэмэгдлийг журмын дагуу дүгнэж, олгох зөвлөмж өгсөн.

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сахилгын шийтгэлтэй 5 ажилтанд 5,070.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-т "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" дахь заалттай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгохгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр /				Зөвлөмж	
							Хүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	1	14.3	1	14.3			1	14.3				

Дүн	1	14.3	1	14.3			1	14.3				
-----	---	------	---	------	--	--	---	------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	5	7.2	2	1.6	1	0.5	2	5	-	-	-	-
Дүн	5	7.2	2	1.6	1	0.5	2	5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	1	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	6	7.2	2	1.6	1	0.5	2	5.0		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй	7	8				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			